



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 447

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нийт 50,654,226.00 (тавин сая зургаан зуун тавин дөрвөн мянга хоёр зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ, 41,358,326.00 (дөчин нэгэн сая гурван зуун тавин найман мянга гурван зуун хорин зургаан) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Ерөнхий боловсролын Шинэ эрин сургуулийн захирал Б.Амартүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-д даалгасугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000854



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн
ЦНТ дугаар тогтоолын хавсралт

Ерөнхий боловсролын Шинэ Эрин сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
акталж, данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтанд орсон огноо	Балансын			Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөл
					нэг бүрийн үнэ	нийт үнэ			
						(төгрөг)			
1	Ухаалаг самбар	ш	1	2012.01.02	3,500,000.00	3,500,000.00	3,500,000.00	-	
2	Ухаалаг самбар	ш	1	2012.01.02	6,100,000.00	6,100,000.00	6,100,000.00	-	
3	Ухаалаг самбар	ш	3	2012.10.31	6,111,116.00	18,333,348.00	18,333,348.00	-	
4	Газардуулагатай, хүйтэн гагнуурын аппарат	ш	1	2012.12.31	798,000.00	798,000.00	798,000.00	-	
5	Джитал видео камер /Samsung/	ш	1	2012.12.07	1,683,192.00	1,683,192.00	1,683,192.00	-	
6	Хүчдэл шулуутгагч	ш	20	2011.11.24	116,500.00	2,330,000.00	2,330,000.00	-	
7	Интеректив цагаан самбар	ш	1	2012.12.07	7,698,786.00	7,698,786.00	7,698,786.00	-	
8	Киппийн аппарат	ш	10	2011.11.24	91,500.00	915,000.00	915,000.00	-	
9	Ном	ш	3910			9,295,900.00		9,295,900.00	
НИЙТ ДҮН					50,654,226.00		41,358,326.00	9,295,900.00	
					(тавин сая зургаан зуун тавин дөрвөн мянга хоёр зуун хорин зургаан)	(дөчин нэгэн сая гурван зуун тавин найман мянга гурван зуун хорин зургаан)	(есөн сая хоёр зуун ерэн таван мянга есөн зуун)		